



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/288

Есөнбулаг сум

Төр, захиргааны байгууллагуудын
ажлын цагийн хуваарьт зохицуулалт
хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалт, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Засгийн газрын 2026 оны 119 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, цаг ашиглалтыг сайжруулах, амралт чөлөөт цагийг зохицуулах зорилгоор аймгийн хэмжээнд төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийг 2026 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал эхлэх цагийг 08:00 цагт, тарах цагийг 17:00 цагт, цайны цагийг 12:00 цагаас 13:00 цаг байхаар өөрчилсүгэй.

2.Энэхүү захирамжийг иргэд, олон нийтэд мэдээлж, сурталчлан таниулах ажлыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Я.Жаргалцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, байгууллагын удирдлагуудад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Д.Эрдэнэжаргал)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

